

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар....

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.10 дах хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг түр хамгаалах байраар үйлчилгээг үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга /С.Тунгалагтамир/, Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Б.Ундрал/ нарт даалгасугай.

4.Энэ журмыг 2017 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Н.НОМТОЙБАЯР

ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Түр хамгаалах байр” гэж хохирогчийг, тодорхой хугацаагаар байрлуулан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан үйлчилгээг үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг хэлнэ.

1.2. Аюулын зэргийн үнэлгээ болон гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн (цаашид уг журамд хохирогч гэх) амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлэх, үйлчилгээний явц, чанар, үр дүнд хяналт тавих, үнэлэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Аюулын зэргийн үнэлгээ болон гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээгээр “дунд”, болон “өндөр” эрсдлийн зэрэгтэй хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалан түр хугацаагаар хамгаалан байрлуулна.

1.4. Хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам”-аар зохицуулна.

1.5. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг “Нэг хүнд ноогдох хувьсах зардлын хэмжээгээр тооцох журам”-аар зохицуулна.

1.6. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлэх үйл ажилагаанд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хяналт тавьж, үнэлгээ хийнэ.

1.7. Түр хамгаалах байрны үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагаанд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль энэхүү журмыг баримтална.

Хоёр. Түр хамгаалах байраар үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

2.1 **Аюулгүй байдлыг тэргүүн ээлжид хамгаална:** Түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлэхдээ хохирогчийн аюулгүй байдлыг тэргүүн зэрэгт тавина.

2.2 **Нууцлалыг чандлан хадгална:** Хохирогчийн нэр төр, үнэ цэнэ, өөртөө итгэх итгэл, үнэлэмж, хувийн нууцтай байх эрхийг хүндэтгэнэ. Хохирогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр түүнтэй холбоотой мэдээллийг задруулах ёсгүй.

- 2.3 **Хохирогчийн зөвшөөрөл, оролцоог хангана:** Түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлэх бүхий л үйл явцад хохирогчийн сонголт хийх, шийдвэр гаргах эрхтэйг хүлээн зөвшөөрнө. Өөртэй нь хамаатай шийдвэр гаргах үйл явцад оролцоог хангана.
- 2.4 **Ялгаварлан гадуурхахгүй байх:** Хохирогчид үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд нас, хүйс, яс үндэс, нийгмийн гарал, боловсрол, шашин шүтлэг, итгэл үнэмшил, үзэл бодол, гэрлэлтийн байдал, эдийн засгийн боломж, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахгүй байна.

Гурав.Удирдлага, зохион байгуулалт

- 3.1 Түр хамгаалах байрыг төрийн, төрийн бус байгууллагын харьяанд сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн харьяалалаар байгуулан ажиллуулж болно.
- 3.2 Түр хамгаалах байрыг төр болон төрийн бус байгууллагын харьяанд байгуулахдаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүн, ахмад настан, эрэгтэй хохирогчдын онцлог хэрэгцээнд нийцүүлэн төрөлжүүлэн байгуулж болно.
- 3.3 Түр хамгаалах байр байгуулан ажиллуулж байгаа төрийн бус байгуулагыг магадлан итгэмжлэх журмын дагуу магадлан итгэмжлэгдсэн байна.
- 3.4 Түр хамгаалах байраар хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүн, ахмад настны онцлог хэрэгцээ шаардлагыг харгалзан үйлчилгээг үзүүлнэ.
- 3.5 Түр хамгаалах байранд үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эрх зүйч ажиллаж, мэргэжлийн үйлчилгээг цогцоор үзүүлнэ.
- 3.6 Түр хамгаалах байрны аюулгүй байдлын хамгаалалтыг цагдаагийн байгууллага, эсхүл гэрээт харуул хамгаалалтын байгууллагаар гүйцэтгүүлнэ.
- 3.7 Хохирогчийг шаардлагатай богино хугацааны нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулж, урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээнд холбон зуучилна.
- 3.8 Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлж буй төр, төрийн бус байгууллага нь ажилтнуудаа давтан сургах, мэргэшүүлэх, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

Дөрөв. Түр хамгаалах байрны үйлчилгээний төрөл

4.1. Түр хамгаалах байрны үйлчилгээ нь суурь болон мэргэжлийн үйлчилгээтэй байна. Үүнд:

4.1.1 Суурь үйлчилгээнд

4.1.1.1.Аюулгүй орон байраар хангах

4.1.1.2.Хоол хүнсээр хангах

- 4.1.1.3.Хувцас, ариун цэврийн хэрэгслээр хангах
- 4.1.2 Мэргэжлийн үйлчилгээнд
 - 4.1.2.1 Аюулгүй байдлын хамгаалалт
 - 4.1.2.2 Эмнэлэгийн тусламж үйлчилгээ
 - 4.1.2.3 Сэтгэл зүйн үйлчилгээ
 - 4.1.-24 Нийгмийн халамжийн үйлчилгээ
 - 4.1.2.5 Хүүхэд хамгааллын үйлчилгээ
 - 4.1.2.6. Эрх зүйн туслалцаа
 - 4.1.2.7. Холбон зуучлах үйлчилгээ
- 4.2. Түр хамгаалах байраар мэргэжлийн үйлчилгээг үзүүлэхдээ тус бүрийн үйлчилгээ үзүүлэх журмаар зохицуулагдана.

Тав. Үйлчлүүлэгчийн эрх

- 5.1 Үйлчлүүлэгч нь нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр үйлчлүүлэх эрхтэй.
- 5.2 Үйлчлүүлэгч нь аюулгүй байдал болон хувийн нууцаа хамгаалуулах эрхтэй.
- 5.3 Анхан шатны болон яаралтай эмнэлгийн тусламж авах;
- 5.4 Үйлчлүүлэгч нь үйлчилгээ үзүүлж буй байгууллага болон үйлчилгээний талаарх мэдээллээр хангагдах эрхтэй.
- 5.5 Хуульд заасан үйлчилгээг цогцоор авах;
- 5.6 Үйлчлүүлэгч өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцож, санал өгөх эрхтэй.
- 5.7 Хүчирхийлэлд өртсөн тухайгаа баримтжуулах;
- 5.8 Үйлчлүүлэгч нь байгууллага, ажилтны гаргасан шийдвэрт гомдол гаргах эрхтэй.
- 5.9 Хохирогч нь түр хамгаалах байрны дотоод журмыг даган мөрдөх.

Зургаа.Хамгаалах байрны ажилтнуудын эрх, үүрэг

- 6.1 Нийгмийн ажилтан нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26-р зүйлд зааснаас гадна, дор дурдсан үүрэгтэй:**
 - 6.1.1 Хохирогчийг хүлээн авч, үйлчилгээг төлөвлөх, үзүүлэх, үнэлэх, дуусгавар болох хүртэлх бүхий л үе шатыг зохион байгуулж, кейс менежерийн үүрэг гүйцэтгэн ажиллах

- 6.1.2 Хамгаалах байрны багийн ажил, салбар хоорондын уялдааг хангах, зангидан зохицуулах
- 6.1.3 хохирогчийн хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзан шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах. 4.1.4.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхэд, өндөр настанд тусгайлсан туслалцаа үзүүлэх.
- 6.1.4 Тухайн байгууллагын мэргэжилтнүүдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг илрүүлэх, мэдээлэх арга зүйгээр хангаж, энэ чиглэлээр сургалт сурталчилгааг зохион байгуулах
- 6.1.5 Хохирогчийн хувийн хэргийг хөтлөх, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулах, үйлчилгээний нэгдсэн тайлан мэдээ гаргах;
- 6.1.6 Эмнэлэгийн байгууллагуудад холбон зуучлах, анхан шатны эмнэлгийн туслалцаа үзүүлэх; үйлчилгээг дуусгавар болгох хүртэл бүхий л үе шатанд эрүүл мэндийн үйлчилгээг хариуцан ажиллах

6.2 Сэтгэл зүйч нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 38 дугаар зүйлд зааснаас гадна дор дурдсан үүрэгтэй:

- 6.2.1 Хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийоны сарын ны өдрийн тоот тушаалаар баталсан журмын дагуу зөвлөгөөг үзүүлнэ.
- 6.2.2 Хохирогчийг хүлээн авч, үйлчилгээг төлөвлөх, үзүүлэх, үнэлэх, дуусгавар болох хүртэлх бүхий л үе шатанд хямралын үеийн сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлэх
- 6.2.3 Хохирогчийг тайвшруулах, цагдаа, хуулийн байгууллагын мэдүүлэг, байцаалт, эмчийн үзлэг зэрэг үйлчилгээг үзүүлэхэд сэтгэл зүйг бэлдэх
- 6.2.4 Хохирогчийн сэтгэл зүйн байдлын талаар дүгнэлт гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх
- 6.2.5 Хохирогчийн сэтгэл зүйн байдлыг судлан тогтоож, шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн сэтгэл заслын эмчилгээнд холбон зуучилж, эргэх холбоотой ажиллах
- 6.2.6 Хохирогчид үзүүлсэн сэтгэл зүйн үйлчилгээний тэмдэглэл хөтлөх, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулах, үйлчилгээний нэгдсэн тайлан мэдээ гаргах;

6.3 Эрх зүйч нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 39 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан үүрэгтэй:

- 6.3.1 Хохирогчид эрх зүйн зөвлөгөөг үзүүлэхдээ хуульд заасан журмын дагуу үзүүлнэ.
- 6.3.2 Хохирогчийг хүлээн авч, үйлчилгээг төлөвлөх, үзүүлэх, үнэлэх, дуусгавар болох хүртэлх бүхий л үе шатны хууль, эрх зүйн зөвлөгөө үзүүлэхтэй холбогдох үүргийг хариуцан ажиллах

- 6.3.3 Шаардлагатай тохиолдолд хохирогчийн хууль ёсны болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах, өмгөөллийн болон бусад үйлчилгээнд холбон зуучлах
- 6.3.4 Хүчирхийлэлд өртсөн болон өртөж байсан талаарх нотлох баримтыг бүрдүүлэх, өргөдөл, гомдол, нэхэмжлэлийг холбогдох хуулийн байгууллагад гаргахад арга зүйн дэмжлэг, туслалцааг үзүүлэх
- 6.3.5 Хүний эрхийн зөрчлийн талаарх гомдлыг холбогдох байгууллагад мэдэгдэж, хамтран ажиллах
- 6.3.6 Хохирогчид эрх зүйн зөвлөгөө үзүүлсэн тухай хувийн хэргийг хөтлөх, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулах, үйлчилгээний нэгдсэн тайлан мэдээ гаргах;
- 6.4 **Цагдаагийн ажилтан нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан үүрэгтэй**
- 6.4.1 Шаардлагатай тохиолдолд хамгийн ойр байгаа цагдаагийн ажилтан нь хамгаалах байрны үйлчилгээнд дуудлагаар ирж эрсдэлийн зэргийн үнэлгээ хийнэ.
- 6.4.2 Цагдаагийн ажилтан нь харьяалах нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулж буй хамгаалах байрны аюулгүй байдлыг хамгаалан ажиллана.
- 6.4.3 Түр хамгаалах байранд байрлаж байгаа хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулахдаа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 43-р зүйлд заасны дагуу журамыг баримтлана.

Долоо. Хориглох зүйл

- 7.1 Хамгаалах байрны ажилтан ажиллах хугацаандаа болон ажлаас чөлөөлөгдсөн /халагдсан/-ий дараа хамгаалах байрны байршил, гэрч, хохирогчийн талаар аливаа төрлийн мэдээлэл хийх, нууцыг задруулахыг хориглоно.
- 7.2 Хүүхдийн асрамж халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагын ажилтан хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар мэдээлэл хийх, нууцыг задруулахыг хориглоно.
- 7.3 Шашны суртал номлолыг дэлгэрүүлэх, ашиг олох, хууль бус үйл ажиллагааг халхавчлах зорилгоор түр хамгаалах байр байгуулах, үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
- 7.4 Түр хамгаалах байранд хүчирхийлэл үйлдэгч нэвтрэх, аливаа хэлбэрээр хохирогчтой холбоо тогтоохыг оролдох, хохирогчид айдас түгшүүр үүсгэх бусад үйлдэл хийх болон түр хамгаалах байрны хэвийн үйл ажиллагаанд саад учруулахыг хориглоно.
- 7.5 Түр хамгаалах байрны ажилтнууд үйлчлүүлэгчтэй хувийн харилцаа тогтоох, мэргэжлийн ёс зүй, хил хязгаарыг зөрчихийг хориглоно.

10001